

**Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/**

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

<i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/</i>	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, Үнэт цаасны код, Утасны дугаар</i>	<b>Алтайн зам ХК, 1610001001, 227 99054087</b>
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	<b>Бумбат алтай</b>
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	<b>Зам гүүр барих, засварлах</b>
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	<b>54153</b>
<i>Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	<b>ТУЗНБД үүрэг гүйцэтгэгч М.Едигаа Гүйцэтгэх захирал Б.Энхбат</b>
<b>1.</b>	
<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>	
<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>	<b>118 530 612 800.51</b>
<i>Орлогын тайлан</i>	<b>3 401 485 499.53</b>
<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	<b>21 975 087 484.76</b>
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	<b>315 738 776.60</b>
<b>2.</b>	
<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>	
<p align="center"><b>"Алтайн Зам" ХК-ийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н аудитын хорооны дүгнэлт, тайлан</b></p> <p>"Алтайн Зам" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдрөөр дуусгавар болгон бэлтгэсэн санхүүгийн тайланг үндэслэн дараах танилцуулга, дүгнэлтийг бэлтгэн танилцуулж байна.</p> <p>Санхүүгийн тайлангийн талаар: "Алтайн Зам" ХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Тус хувьцаат компанийн 2023 оны 01 дүгээр сарын 05-ний өдрийн НПГ ТУЗ2023006 тоот тогтоолоор баталсан. Тус компанийн 2023 оны үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийг авч үзвэл дараах байдалтай байна.</p> <p>Орлого: 2023 онд 212,013.7 сая төгрөгийн нийт орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр эхний хагас жилийн байдлаар 87,143.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, нийт орлогын төлөвлөгөө хагас жилийн орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 41 хувийн биелэлтэй байна. Үүний 93.9 сая төгрөг нь үндсэн үйл ажиллагааны бус бусад орлого буюу хөрөнгө борлуулсан, ханшийн зөрүүгийн орлого байна.</p> <p>Зардал: 2023 онд төлөвлөгөөгөөр 159,206.9 сая төгрөгийн нийт зардалтай ажиллахаас гүйцэтгэлээр 83,445.7 сая төгрөгийн зардал гаргасан нь хагас жилийн зардлын төлөвлөгөөнөөс 4.8 хувийн буюу 3,842.3 сая төгрөгийн хэтрэлтэй гарсан байна.</p> <p>Ашиг: Тайлант хугацаанд 52,806.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэлээр 3,401.5 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.</p>	

2023 оны санхүүгийн зорилтын биелэлт /сая төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төлөвлөгөө хагас жил	Гүйцэтгэл 2022.06.30	Зөрүү	Гүйцэтгэлийн /хагас жил/ %
Борлуулалтын орлого	212,013.70	106,006.85	87,143.40	(18,863.45)	82.2%
Борлуулалтын өртөг	159,206.90	79,603.45	83,445.70	3,842.25	104.8%
Нийт ашиг	52,806.80	26,403.40	3,697.71	(22,705.69)	14.0%
Үйл ажиллагааны зардал				-	
ҮАБус орлого			93.97	93.97	
ҮАБус зардал			6.54	6.54	
Татварын өмнөх ашиг	52,806.80	26,403.40	3,785.13	(22,618.27)	14.3%
Татвар			383.65	383.65	
Татварын зараах ашиг	52,806.80	26,403.40	3,401.49	(23,001.91)	

Авлага:

Авлага өмнөх оноос 17,346 сая төгрөгөөр өсөж, нийт 62,687.6 сая төгрөг болсон байна. Дансны авлага 32.8 сая төгрөгөөр, бусад авлага 17,313.1 сая төгрөгөөр тус ус өсч, Татвар, НДШ-ийн авлага 0.2 сая төгрөгөөр өсчээ.

Өр төлбөр:

Богино хугацаат өглөг /урьдчилж орсон орлого орсон/ оны эхнээс 27,362.4 сая төгрөгөөр өсөж 86,189.3 сая төгрөг болсон байна. Дансны өглөг 5,191.3 сая төгрөгөөр, татварын өглөг 1,680.3 сая төгрөгөөр, НДШ-ийн өглөг 203.6 сая төгрөгөөр өссөн, бусад богино хугацаат өр төлбөр 3,065 сая төгрөгөөр буурсан байна. Урт хугацаат өр төлбөр 1,554.1 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө:

Үндсэн хөрөнгө 47,958.7 сая төгрөг болж 12,100.1 сая төгрөгөөр өссөн нь 14,814.9 сая төгрөгийн худалдан авалтын хөрөнгө орлого авч, 2,708.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан, 5.9 сая төгрөгний үлдэгдэлтэй өртөгтэй хөрөнгө данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө 10.6 сая төгрөгийн хорогдол байгуулснаар 39.9 сая төгрөг болсон байна.

Дүгнэлт:

“Алтайн Зам” ХК-ийн 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдрөөрх санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Компанийн бодлогын баримт бичиг холбогдох, хууль тогтоомж, стандартад нийцсэн байна, дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дотоод аудитын тайланд дурджээ.

Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтээс харахад 2023 оны орлогын төлөвлөгөө 41.1% хувийн гүйцэтгэлтэй гарсан боловч орлогтой харьцуулахад зардал хэтэрч, зардал хэмнэх арга хэмжээг хангалттай авч ажиллаагүй байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оны жилийн эцсээс 46.5% хувиар өссөнд анхаарч өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Аудитын газрын зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлж цаашид тухайн төрлийн зөрчил гаргахгүй байхад анхаар ажиллах;
- Аудитын тайлангаар залруулагдсан алдааг дахин давтан гаргахгүй байх;
- Төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, орлого, үр дүнг дээшлүүлэх талаар оны эхнээс анхаарч ажиллах;
- Авлага, өглөг бууруулах ажил зохион байгуулж компанийн зорилтот түвшний хэрэгжилтийг жигд ханган биелүүлэх талаар үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах.

АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
АУДИТЫН ХОРОО

3. Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1 Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Хэвийн
3.2 Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт	Хэвийн
3.3 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	
Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	
Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
<b>Байхгүй</b>	
Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
Засаглалын кодексыг шинэчлэн баталсантай холбогдуулан 2021 онд баталсан Кодексыг үл тохирол байгаа эсэхийг ажлын хэсэг гарган хянуулсан ба ямар нэг үл тохирол байгаагүй тул үйл ажиллагаандаа хэвийн мөрдөж байна.	
Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: ..... *М.Булгаа* .....

Албан тушаал: ..... *МЗНБЯ-ийн үүрэг үйлчилгээ* .....

Гарын үсэг: ..... *М.Булгаа* .....